

**ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН БАЙГУУЛЛАГЫН АЗИ, НОМХОН
ДАЛАЙН БҮСИЙН АГААРЫН НАВИГАЦИЙН ТӨЛӨВЛӨЛТ,
ХЭРЭГЖИЛТИЙН “ЦАГ УУРЫН АЖЛЫН ДЭД ХЭСГИЙН (MET SG/28)” 28
ДУГААР ХУРАЛД ОРОЛЦСОН АЖЛЫН ТАЙЛАН**

2024-07-17

Тайландын Вант Улсын Бангкок хотод зохион байгуулагдсан Ази, номхон далайн бүсийн агаарын навигацийн төлөвлөлт, хэрэгжилтийн цаг уурын ажлын дэд ажлын хэсэг (APANPIRG/MET SG/ 28)-ийн 28 дугаар хуралд 2024 оны 07 сарын 08-12-ний өдрүүдэд Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга Б.Болормаа, Аюулгүй байдал, чанарын хяналтын ахлах мэргэжилтэн Н.Энхдалай нар амжилттай оролцлоо.

Энэ удаагийн хуралд Австрали, Бутан, Камбожа, Хятад, Хонг Конг Хятад, Макао Хятад, Бүгд Найрамдах Фижи Улс, Бүгд найрамдах Индонез улс, Япон, Бүгд найрамдах ардчилсан Лаос ард улс, Малайзын холбооны улс, Мальдив, Монгол, Шинэ Зеланд, Филиппин, Өмнөд Солонгос, Сингапур, Тайланд, АНУ, Вьетнам зэрэг 19 улс, Дэлхийн цаг уурын байгууллага, Олон улсын иргэний нисэхийн байгууллагын нийт 65 төлөөлөгч оролцлоо. Хурлыг Ази Номхон далайн бүсийн захирал Арун Мишрагийн нэрийн өмнөөс хурлын дарга Mr Pak-wai Chan, Mr Peter Dunda нар нээж үг хэллээ. Тус хурлыг Mr. Pak-wai Chan даргалж, хурлын дэд даргаар Mr Goh Wee Poh сонгогдож, нарийн бичгийн даргаар Mr. Peter C. Dunda ажиллаж, хурлыг тус тус удирдан явуулсан.

Энэхүү хурлаар нийт 19 улс 8 сэдвээр агаарын навигацийн үйлчилгээний цаг уурын чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэхээр ажиллаж буй төсөл, үүссэн хүндрэл бэрхшээл, харилцан мэдээлэл солилцоо, хэлэлцүүлэг зэрэг 46 асуудал 22 ажлын хуудас “WP”, 16 мэдээлэх хуудас “IPs”, 5 илтгэх хуудас “SP”, 3 дүгнэлт, өөрчлөлтийн хуудас “Flimsy” хэлэлцсэн.

Монгол улсын төлөөлөгчид Ази, номхон далайн бүсийн цаг уурын мэдээлэл солилцооны гарын авлага (ROBEX handbook) –д Хөшигийн хөндий дэх Чингис хаан олон улсын нисэх буудал (ZMCK) –аас гаргадаг цаг уурын мэдээлэл (аэродромын цаг агаарын бодит ажиглалтын мэдээ, урт хугацааны урьдчилсан мэдээ TAF, нислэгийн замын дагуух цаг агаарын аюултай үзэгдлийн мэдээ WS SIGMET мэлээлэл)-ийг оруулсанд талархал илэрхийлж, “Монгол улсын цаг уурын үйлчилгээ ба METAR мэдээ” мэдээлэх хуудас IP/02 илтгэл тавьж, хэлэлцүүлсэн(Зураг 1). Мөн агаарын навигацийн үйлчилгээний цаг уурын үйлчилгээ, мэдээлэл солилцоо, хэрэгцээ, шаардлагын чиглэлээр харилцан туршлага солилцож мэдээлэл авсан цаашдын хэтийн төлөвлөлтөд чухал нөлөөтэй хурал болсон.

Хурлаар Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас нисэхийн цаг уурын чиглэлээр дэлхийн болон бүсийн хэмжээнд баримталж буй бодлого, төлөвлөгөө нэн тэргүүний зорилго, зорилтуудыг эргэн нягталж, Чикагогийн конвенцийн Хавсралт-3 т 81, 82 дугаар нэмэлт өөрчлөлтөөр орох Олон улсын цаг уурын

Category : 4-Information Papers (16)

IP/01	Meeting Bulletin	26 June 2024	Secretariat
IP/02	METAR Bulletins and MET Service of Mongolia	26 June 2024	Mongolia

Зураг 1. “Монгол улсын цаг уурын үйлчилгээ ба METAR мэдээ” мэдээлэх хуудас IP/02

мэдээлэл солилцооны IWXXM форматын улс орнууд үе шаттай хэрэгжүүлэлт, шинэчлэлт, онцгой үзэгдлийн зураг зэргийг танилцуулсан. Мөн SIGMET мэдээний шинэчлэлт, хөрш зэргэлдээх улс орнуудын SIGMET мэдээний хамтын ажиллагаа, WAFS бүтээгдэхүүний шинэчлэлтийн тухай болон агаарын навигацийн үйлчилгээг үзүүлж буй цаг уурын мэдээлэл солилцоо, хэрэгцээ, шаардлага, үйлчилгээний чиглэлээр хийгдсэн ололт амжилттай ажлуудын талаар яригдлаа. Үүнд:

- Бүсийн сансрын цаг уурын зөвлөмж, мэдээллийн үйлчилгээний хувьд бүсийн 4 төвүүд байна. Үүнд:

1. Австрали, Канад, Франц болон Япон улсын консорциум (ACFJ)
2. БНХАУ, ОХУ-ын консорциум (CRC)
3. Европийн консорциум (PEGASUS)
4. АНУ

Глобал төвүүд байнга идэвхтэй байдаг ба дараах үүргүүдээр ээлжлэн ажилладаг. Үүнд:

- Төвийн үүрэг нь тодорхойлогдсон сансрын цаг уурын зөвлөмжийн мэдээллийг дамжуулах, боловсруулах
- Үндсэн нөөцийн төв
- Хоёрдугаар нөөцийн төв
- Ажиглалтын болон техникийн үйлчилгээний төв

Сансрын цаг уурын бүсийн төвүүд нь үндэсний ОРМЕТ төвүүдэд мэдээллээ илгээдэг. Улс орнуудын хувьд Анпех 3-т тусгагдсаны дагуу олон улсын агаарын навигацийн үйлчилгээг дэмжих сансрын цаг уурын мэдээний гарын авлагын дагуу нисэх багийн гишүүд, агаарын тээвэрлэгчид, нислэг хөдөлгөөний үйлчилгээний нэгж, эрэн хайх авран туслах нэгж, нислэгийн менежмент зэрэг бусад хэрэглэгчдийг сансрын цаг уурын мэдээллээр хангана.

- Дэлхийн бүсийн урьдчилан мэдээлэх систем (WAFS)-ийн шинэчлэлийн хувьд онцгой үзэгдлийн зургийг шинэчилсэн. Үүнд:

- Олгойдох урсгалын мэдээлэл,
- тропопаузын өндрийг хаяалбар хэлбэрээр,
- хэсэг хэсэг борооны бөөн үүл (OCNL CB) эсвэл үргэлжилсэн борооны бөөн үүл (FRQ CB) -ний бүс,
- дэлхийн бүсийн урьдчилан мэдээлэх систем (WAFS)-ийн хүчтэй сэгсрэлтийн бүсэд үндэслэн хүчтэй болон дунд хүчтэй сэгсрэлтийг урьдчилан мэдээлэх.
- Дунд болон хүчтэй мөстөлтийн бүс (Дэлхий нийтээр гаргана)
- Идэвхтэй галт уулын дэлбэрэлт, тропикийн циклоны байршил, цацрагийн идэвхжилтийн мэдээллүүд

- 2024 оны 05 дугаар сарын 09-16-ны өдрүүдэд БНХАУ-д Иргэний нисэхийн үйл ажиллагаанд нийт 108 удаагийн хэвийн бус харилцаа холбоо, навигацийн тохиолдлуудын мэдээллийг хүлээн авсан. 05 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд нарны идэвхжил өндөр түвшинд хүрч хэмжигдсэн. Иймд сансрын цаг уурын зөвлөмжийн мэдээллийн ач холбогдлыг харуулсан чухал илтгэлийг БНХАУ танилцуулсан.
 - Австрали улс
 - SIGMET хамтын ажиллагааны хувьд БНХАУ болон БНАСҮ “дуу цахилгаантай аадар борооны SIGMET” хамтын ажиллагааг 2022 оны 09 сарын 01-нд эхлүүлсэн. Тус хамтын ажиллагаа нь нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага зэрэг бусад хэрэглэгчдэд өндөр үр дүнтэй байсан тул 2023 оны 10 дугаар сараас SIGMET хамтын ажиллагааг тогтвортой явуулахаар шийдвэрлэсэн.
 - Бангладеш, БНХАУ-ын Засаг захиргааны бүс Хонг Конг, Бүгд найрамдах Энэтхэг ард улс, Бүгд найрамдах Индонез улс, Мальдив улс, Мьянмар улс, Бүгд найрамдах холбооны ардчилсан Непал улс, Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри-Ланк Улс нар тропикийн циклоны SIGMET хамтын ажиллагааны үр дүнг танилцуулсан. Үүнд: Тропикийн циклоны хамтарсан хэлэлцүүлэг хийснээр SIGMET мэдээний чанар, үр дүн сайжирсан тухай мэдээлсэн.
 - SIGMET хамтын ажиллагаанд Ази, номхон далайн орнууд нэгдэж, үр дүнтэй байгаа тухай мэдээлсэн. Түүнчлэн ОХУ нь БНХАУ-тай SIGMET хамтын ажиллагаанд нэгдсэн байна.
 - Хурлын үеэр БНХАУ-ын Нисэхийн цаг уурын албатай Монгол улсын төлөөлөгчид уулзсан. 2024 оны 09 дүгээр сард болох Монгол улсын Иргэний нисэхийн ерөнхий газар болон БНХАУ-ын Иргэний нисэхийн удирдах газрын Нисэхийн хөдөлгөөний менежментийн товчоо хоорондын хамтарсан уулзалтад ирэх тухай мэдээлэл солилцсон.
 - Шинэ Зеланд 2023 оны SIGMET тестийн дүнг танилцуулсан. Үүнд Монгол улс тропикийн циклоны SIGMET мэдээ, галт уулын үнсний SIGMET мэдээ, бусад цаг агаарын аюултай үзэгдлийн SIGMET мэдээний тестэд амжилттай оролцсоныг тэмдэглэж, мэдээлсэн.
 - ROBEX гарын авлагад Ази, номхон далайн бүсийн SIGMET мэдээлэл, тропикийн циклоны зөвлөмжийн мэдээлэл, галт уулын үнсний зөвлөмжийн мэдээллийг IWXXM формат болон TAC-форматаар дамжуулах схемд өөрчлөлт орж буйг танилцуулсан. Тус өөрчлөлтийг цаг уурын дэд ажлын хэсгийн мэдээлэл солилцоо (MET/IE WG/23) ажлын хэсгийн хурлаар ярилцсан байна.
- Ази, номхон далайн бүсийн цаг уурын дэд ажлын хэсгийн мэдээлэл солилцоо (MET/IE WG/23) ажлын хэсгийн хурал 2025 оны 03 сарын 24-27, цаг уурын хэрэгцээ, шаардлага (MET/R WG/14) ажлын хэсгийн хурал болон ATFM/SG ба MET/ATM Seminar 2025 оны 04 эсвэл 05 дугаар сард тус тус зохион байгуулагдахаар шийдвэрлэсэн.

Эцэст нь дүгнэхэд, Ази номхон далайн бүсийн улс орнуудын агаарын навигацийн үйлчилгээ үзүүлж буй цаг уурын үйлчилгээний чиглэлээр хийгдэж байгаа ажлууд, төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаатай танилцаж Монгол улсын хувьд дээрх төсөл хөтөлбөрүүдэд оролцох, Чингис хаан олон улсын нисэх буудлын мэдээллийг танилцуулсан, тухайн бүс нутгийн улс орнуудтай харьцуулах, туршлага судлах боломжийг бүрдүүлсэн ач холбогдолтой хурал боллоо.

Тайлан бичсэн:

Мэдээлэл, үйлчилгээний
хэлтсийн дарга



Б.Болормаа

Аюулгүй байдал, чанарын
хяналтын ахлах мэргэжилтэн



Н.Энхдалай

Танилцсан:

Дарга



Б.Баньдсүрэн